

**“БАЯЛАГ СҮМБЭР ХК”-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 9-р сарын 30


№ 19/9- 2

Улаанбаатар хот

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал
зарлан хуралдуулах тухай*

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 61.1.5, 67.1, 71.3, 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14 ны өдрийн 377 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн зар хүргэх журам”, Баялаг сүмбэр ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2019 оны 9-р сарын 30-ны өдрийн “Төлөөлөн удирдах зөвлөл”-ийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2019 оны 11 сарын 18- ны өдрийн Даваа гарагт 10:00 цагт “Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Мандал хотхон, 42-11 тоот” хаягт зарлан хуралдуулсугай.
2. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 10 сарын 21-ны өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдэд ээлжит бус хурлын материалыг 2019 оны 10 сарын 09 ны өдөр үнэт цаасны компанид цахим шуудан болон бичгээр илгээх ба хувьцаа эзэмшигчид компанийн байранд дээрх өдрөөс хойш ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд ирж танилцаж болохыг түгээсүгэй.
4. Бичгээр санал авах хуудсыг хүлээж авах сүүлийн хугацааг 2019 оны 11 сарын 15-ны өдрөөр тогтоож, компанийн байранд авахаар тогтоосугай.
5. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2019 оны 10 сарын 04-ний өдөр болон, давтан 15 хоногийн дараа буюу 10 сарын 18 ны өдрөөр тогтоож, зарын агуулгыг “хавсралт №3”-оор баталсугай..
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулах комиссын даргаар Компанийн Гүйцэтгэх захирал Хе Жинвен-г томилсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Компанийн Гүйцэтгэх захирал Хе Жинвен-г томилсугай.
8. Хурлын тооллогын комиссын даргаар Б.Батцэцэг-г, гишүүнээр Э.Анхбат нарыг томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг “хавсралт №1”-ээр баталсугай.



**“БАЯЛАГ СҮМБЭР ХК”-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг “хавсралт №2”-аар баталсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд санал авах хуудсыг “хавсралт №4”-өөр баталсугай.

九月 30 , 2019 No.19 / 9-2 Ulaanbaatar

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



/LIN YU FEI/